



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №3

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусийн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2020 оны 2 дугаар сарын 17 ноос 3 дугаар сарын 02-ыг хүртлэх хугацаанд шувууны томуугийн А хүрээний вирус Польш, Болгар (анхны тохиолдол), Вьетнам, Энэтхэг зэрэг оронд шувуунд илрээд байна. Польш -д 7 удаа өвчлөл бүртгэгдэж 35286, Болгар улсад 2 удаа өвчлөл бүртгэгдэж 54, Вьетнам улсад 13 удаа өвчлөл бүртгэгдэж 4274, Энэтхэг улсад 1 удаа өвчлөл бүртгэгдэж 1348 тэжээмэл шувууд өвчилж үхсэн байна (хүснэгт 1, зураг 1).

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 2 дугаар сарын 17 ноос 3 дугаар сарын 02-ны байдлаар шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдээгүй байна.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 02 дугаар сарын 17- ноос 2020 оны 3 дугаар сарын 02-ыг өдрийг хүртлэх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

2013-2018 хүртэл 5 жилийн хугацаанд Бээжин хот болон 5 мужид шувууны томуугаар өвчилж, эмчлэгдсэн 61 иргэдэд 3, 6, 12 сар тутамд очиж тандалт судалгаа хийсэн байна. Үзлэгээр амьсгалын дутагдал илрүүлэх цээж чагнах, цээжний компьютертомограф, уушигны үйл ажиллагааны сорил хийсэн. Энэхүү халдвар нь өмнө мэдээлж байснаас илүү удаан хугацаанд уушгинд нөлөөлж байгааг тогтоосон ба судалгаагаар уушиг гэмтэж, уушигны үйл ажиллагаа алдагдаж байсныг тогтоосон. Хятадын судалгааны баг энэхүү судалгааны үр дүнгээ 2020 оны 02 дугаар сарын 18 нд зарласан байна.

Үзлэгийн 18 дах сард уушигны ерөнхий дутагдалын түвшин нийт хүний 38.5%, цээжний компьютертомограф оношлогоогоор нийт хүний 78.2%-д нь ямар нэг өөрчлөлт байсан. Эхний үзлэгээр буюу 3 дахь сард уушигны үйл ажиллагааны сорилоор уушигны халдвар нийт хүний 38.1% байсан ба аажим эдгэрч эхэлсэн. Мөн хугацаанд нийт хүний 14.3% илэрсэн уушигны бөглөрөл жилийн хугацаанд бүрэн эдгээгүй. Тэд мөн уушигны дутагдал эдгэж эхэлсэний дараа цээжинд компьютертомограф оношлогоогоор өөрчлөлт байгааг тогтоосон.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 02 дугаар сарын 17- ноос 2020 оны 3 дугаар сарын 02-ыг хүртлэх хугацаанд

шувууны томуугийн А хүрээний (H9N1) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 2 дугаар сарын 17- ноос 2020 оны 3 дугаар сарын 02-ыг хүртлэх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна. 2018 оны 2 дугаар сарын 14-нд хүний өвчлөлийн анхны тохиолдол БНХАУ-ын Жинсу мужид бүртгэгдсэн.


ДОЛОО. 2020 оны 2 дугаар сарын 17 ноос 3 дугаар сарын 02-ыг хүртлэх хугацаанд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувууны мэдээлэл:

(хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт болон вирусийн хэлбэр

Огноо	Хэлбэр	Улс	Муж	Өвчилсөн	Үхсэн	Устгасан
15/2/2020	H5N6	Вьетнам	Танг Хоа	3646	903	2743
16/2/2020	H5N6	Вьетнам	Бак Нинх	743	100	643
16/2/2020	H5N6	Вьетнам	Нинх Бинх	1917	100	1817
17/2/2020	H5N6	Вьетнам	Танг Хоа	4075	254	3821
17/2/2020	H5N6	Вьетнам	Тай Бинх	3646	1000	2646
17/2/2020	H5N6	Вьетнам	Ханной	1991	500	1491
18/2/2020	H5N6	Вьетнам	Ханной	2258	452	1806
19/2/2020	H5N6	Вьетнам	Нэ Ан	37	30	7
20/2/2020	H5N6	Вьетнам	Танг Хоа	412	20	392
20/2/2020	H5N6	Вьетнам	Танг Хоа	670	120	550
20/2/2020	H5N6	Вьетнам	Танг Хоа	260	10	250
21/2/2020	H5N6	Вьетнам	Танг Хоа	1950	500	1450
21/2/2020	H5N6	Вьетнам	Хай Понг	3770	285	3485
7/2/2020	H5N8	Польш	Ворминск Мазурски	17060	1179	15881
19/2/2020	H5N8	Польш	Ополски	6960	4493	2467
20/2/2020	H5N8	Польш	Лодзки	18799	77	18722
20/2/2020	H5N8	Польш	Сласки	49321	11432	37889
21/2/2020	H5N8	Польш	Лодзки	56503	14011	42492
22/2/2020	H5N8	Польш	Вилкофолски	9046	794	8252
22/2/2020	H5N8	Польш	Лодзки	12700	3300	9400
24/2/2020	H5N8	Булгар	Фловдив	55437	34	55403
24/2/2020	H5N8	Болгар	Фловдив	11600	20	11580
20/2/2020	H5N1	Энэтхэг	Одиса	2372	1348	1024

Эх сурвалж: Oie.int

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт /зургаар/



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шувууны томуу хариуцсан баг